МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний аудитын газар
2017 он

Агуулга

Агуулга 2
Товчилсон үгийн жагсаалт 3
Аудитын нэр, код 4
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх 4
Аудитын зорилт 4
Аудитын хамрах хүрээ 4
Үндсэн мэдээлэл 4
Эрсдэлийн үнэлгээ 5
Аудитын арга зүй 5
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд 5
Аудитын хугацаа 6
Аудит хийх багийн бүрэлдэхүүн 6
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам 6
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц 6

Хавсралт №1 Эрсдэлийн үнэлгээ
Хавсралт №2 Асуудлын шинжилгээ
Хавсралт №3 Аудитын арга зүй
Хавсралт №4 Аудитын хөтөлбөр
Судалгаа №1, №2

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНАГ	Аймаг, нийслэлийн аудитын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
МТШХХГ	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
УИХ	Улсын Их Хурал
УУЯ	Уул уурхайн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ХҮРЭЛБААТАР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүн

2. Аудитын код:

ҮАГ-ГАГ/2017/01-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнг шалган холбогдох байгууллага, албан тушаалтанд дүнг танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ.
Үүнд:

- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөлт оновчтой эсэх,
- Төсвийн ерөнхийлөн захирагчид зорилт, арга хэмжээний биелэлтийг үр нөлөөтэй зохион байгуулсан эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд биелэлт, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэх.

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, зарим агентлаг хамрагдана.

6. Үндсэн мэдээлэл:

УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоолд зааснаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгожээ

Үндсэн чиглэлд 5 бодлогын хүрээнд 22 зорилтыг хэрэгжүүлэхээр 158 төсөл, арга хэмжээг тусгажээ. Үүнд:

- Макро эдийн засгийн бодлогын 3 зорилт, 23 арга хэмжээ,
- Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын 7 зорилт, 46 арга хэмжээ,
- Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын 4 зорилт, 25 арга хэмжээ,
- Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлогын 5 зорилт, 43 арга хэмжээ,
- Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогын 3 зорилт, 21 арга хэмжээ байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг улсын төсвийн 233.9 тэрбум, орон нутгийн төсвөөс 0.69 тэрбум, гадаад эх үүсвэрээс 93.6 тэрбум, 86.7 сая ам.доллар, ТХХТ-ийн 927.0 тэрбум төгрөг, 1.131 тэрбум ам.доллар, Хөгжлийн банкны 110.0 тэрбум, зээл, тусламж, сангийн 7.0 тэрбум, бусад эх үүсвэрийн 33.5 тэрбум, нийт 1,405.9 тэрбум төгрөгийн, 1.2 тэрбум ам.долларын хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

7. Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн шатанд судалсан баримт материал, урьдчилсан дүн шинжилгээ, судалгаанд үндэслэн ерөнхий эрсдэлийг "ДУНД" гэж үнэлсэн. (Хавсралт №1-д үзүүлэв)

8. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг ашиглан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, хэрэгжилтийн судалгаа тодруулга авах, хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнээс түүвэрчлэн шалгах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулна.

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн акт, бодлогын бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- УИХ-аас батлсан "Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого" болон урт, дунд хугацааны хөтөлбөр, төрөөс баримтлах бодлогын бусад баримт бичиг;
- "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журмыг батлах тухай" УИХ-ын 2004 оны 2 дугаар тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоол;
- Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хууль;

- "Монгол Улсын 2016 оны төсвийн тухай" хуулиар батлагдсан улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалт;
- Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол;
- Монгол Улсын Их хурлын 2016 оны 43-р тогтоолын 1.1-р заалт;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд;

10. Аудитын хугацаа:

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2017 оны 1 дүгээр сарын 3-наас, талбарын ажлыг 1 дүгээр сарын 23-наас 2 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, тайлангийн төслийг 3 дугаар сарын 9-ний дотор бэлтгэж, чанарын хяналтад шилжүүлэн, нэгдсэн тайланг 3 дугаар сарын 28-ны дотор ҮАГ-ын Аудитын зөвлөлөөр хэлэлцүүлж, 3 дугаар сарын 31-нд УИХ-д хүргүүлсэн байна.

11. Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын дарга М.Наранжаргал удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг чиглэлийн албаны менежер Д.Баттулга хэрэгжүүлж, ГАГ-ын чиглэлийн аудитын албаны аудитор, шинжээч нар хөтөлбөрт заасан хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

12. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, аудитын зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдэнэ. Аудитын тайланг ҮАГ-ын Аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Ерөнхий аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

13. Аудитын хөтөлбөр: /Хавсралт №4/

14. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

А. Боловсон хүчин: 8 хүн – 496 хүн/өдөр
Б. Аудитын нийт өртөг: 28.8 сая төгрөг
В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, сканнер болон бусад техник хэрэгсэл
Г. Бичиг хэргийн зардал 70.0 мян төгрөг
Нийт зардал 29.5 сая төгрөг

Аудитын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:

ҮАГ-ЫН ДЭД ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БАТТУЯА

Боловсруулсан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНЖАРГАЛ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР Д.БАТТУЛГА

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР
ШИНЖЭЭЧ



Ж.ЭРДЭНЭ
Б.БОЛОРМАА
М.ДОРЖМАА
Ш. НАРАНБААТАР
С.ОДОНЦЭЦЭГ
Г.МӨНХЧИМЭГ
И.ТУЯАДАРЬ

2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр

Аудитын эрсдэлийн үнэлгээ

№	Эрсдэл	Магадлал /их/дунд/бага/	Үр дагавар /их/ дунд/бага/	Үнэлгээ /их/ дунд/бага/
1	Үндсэн чиглэлийн арга хэмжээ холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй байх	Бага	Бага	Бага
2	Төсөл арга хэмжээ нь үндсэн чиглэлийн төлөвлөгөөний зорилтын агуулагыг дэмжээгүй байх	Дунд	Дунд	Дунд
3	Хэрэгцээ шаардлага, ач холбогдолгүй, тооцоо судалгаанд үндэслээгүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхой бус арга хэмжээ төлөвлөсөн байх	Бага	Их	Дунд
4	Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэргүй байх	Их	Их	Их
5	Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагын төлөвлөсөн арга хэмжээний саналыг харгалзан үзээгүй байх	Их	Их	Их
6	Салбарын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээг үндсэн чиглэлд нэмэлтээр оруулан батлуулсан байх	Их	Их	Их
7	Тухайн ондоо хэрэгжих боломжгүй арга хэмжээг төлөвлөсөн байх	Их	Их	Их
8	Жил бүр шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ хүрч хэрэгждэггүй арга хэмжээг давтан төлөвлөсөн байх	Их	Их	Их
9	Зарим арга хэмжээний хүрэх түвшингийн хувь, үзүүлэлт жил бүр өөрчлөгдөхгүй нэг түвшинд төлөвлөгдсөн байх	Дунд	Дунд	Дунд
10	Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байх	Бага	Бага	Бага
11	Хэрэгжүүлэгч байгууллага өөрчлөгдсөнөөс арга хэмжээ хэрэгжээгүй орхигдсон байх	Дунд	Дунд	Дунд
12	Нийслэл болон аймаг, орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байх	Дунд	Дунд	Дунд
13	Хариуцан болон хамтран хэрэгжүүлэх байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлтэй уялдаагүй байх	Дунд	Дунд	Дунд
14	Санхүүжилт саатсан, хөрөнгө оруулалт олгогдоогүй байх, хэрэгжилтийн явцад хяналт хангалтгүй байх, тулгарсан асуудлыг тухай бүрт нь шийдвэрлээгүй байх	Дунд	Дунд	Дунд
15	Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хугацаанд нь нэгтгэн тайлагнаагүй байх	Бага	Бага	Бага
16	Батлагдсан тогтоол, шийдвэр, дүрэм журмын дагуу тайлагнаж, бодитой үнэлж дүгнээгүй байх	Бага	Дунд	Дунд
17	Хэрэгжээгүй, хэрэгжилт дутуу арга хэмжээний шалтгаан, үр дагаварыг тооцож тодорхойлоогүй байх	Дунд	Дунд	Дунд
18	Сангийн яамнаас төсөл, арга хэмжээний явц, хэрэгжилтэд өгсөн үнэлэлт дүгнэлт нь ТЕЗ-ийн үнэлгээтэй давхацсан байх	Дунд	Дунд	Дунд
Ерөнхий үнэлгээ		Ерөнхий эрсдэлийг "Дунд" гэж үнэлсэн болно.		

Бага гэж үнэлсэн "3"

Дунд гэж үнэлсэн "10"

Их гэж үнэлсэн "5"

Асуудлын шинжилгээ

1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Хавсралт 2

УХАСТ 22

1.1 Үндсэн чиглэлийн арга хэмжээг бодлогын баримт бичигт үндэслэн бодитой төлөвлөсөн уу?

1.1.1- Үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээг боловсруулахдаа хууль тушаал, шаардлагыг үзүүлэлтийг бодитой тогтоосон уу?

1.1.2- Өмнөх онуудаас дамжин жил бүр үндсэн чиглэл тусгагдаагүй арга хэмжээг дахин төвөгхөөө хэрэгжих үндэслэлийг тооцож байна уу?

1.1.3- Үндсэн чиглэлийн арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг тооцоолсон уу?

1.1.4- Үндсэн чиглэлийн арга хэмжээ хэрэгжүүлэх хөрөнгө төсвийн болон бусад эх үүсвэрээр батлагдсан уу?

2.1 Хэрэгжүүлэгч байгууллагууд үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

2.2.1- Үндсэн чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг үр дүнтэй зохион байгуулсан уу?

2.2.2- Батлагдсан хөрөнгийн эх үүсвэр нь арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүрэлцсэн үү?

2.2.3- Зорилт арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө аравнан хэмжигдэхүйц, үр дүнтэй зарцуулсан уу?

2.2.4- Хэрэгжилт дүгнэлт, хэрэгжүүлэгч арга хэмжээнүүдийн шаглаан нэхцөлийг тодорхойлж, хойшлох алдаан түшаалтанд хариуцлага тооцсон уу?

3.1 Үндсэн чиглэлийн арга хэмжээг биелэлтийг бодитой үнэлж тайлагнасан уу?

3.1.1- Үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээний гүйцэтгэлийн үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн үү?

3.1.2- Үндсэн чиглэлийн биелэлтийг хойшлогдох жүрмын дагуу үнэн зөв тайлагнасан уу?

3.1.3- Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд таних дотоод хяналт үр нөлөөтэй байна уу?

Хавсралт 3

Аудитын нотлох зүйл цуглуулах арга зүй

Аудитын асуулт	2 дах түвшний асуулт	3 дах түвшний асуулт	Шалгуур	Нотлох зүйлс	Нотлох зүйлсийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах аргууд	Мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргууд	Аудит болон дүн шинжилгээ хийхэд гарч болох хязгаарлалтууд
Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?			Ямар стандарттай харьцуулж хэмжих вэ?	Асуултад ямар нотлох зүйл хариулт өгөх вэ?	Нотлох зүйлийг хаанаас олж авах вэ?	Нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?	Олж авсан нотлох зүйлийг яах вэ?	Юу хийх боломжгүй байна вэ?
Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?	1.1 Үндсэн чиглэлийн арга хэмжээг бодлогын баримт бичигт үндэслэн бодитой төлөвлөсөн үү?	1.1.1 Үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээг боловсруулахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг бодитой тогтоосон уу?	-Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл, .УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоол, -УИХ-аас баталсан “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, -“Төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүд”, -УИХ-аас баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам”, -УИХ-аас баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд	-ТЕЗ-дын дэлгэрэнгүй төлөвлөгөө, -Харьцуулсан судалгаа, -Байгуулсан гэрээ, хэлцэл, -Удирдлагын тайлбар, -Үндэслэл бүхий бусад эх сурвалж, -Баримт (тоон нотлох зүйл, дүрсэлсэн нотлох зүйл, чанарын шинжтэй мэдээлэл)	-Хариуцан хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага, -Тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн, -Хэрэгжилтийн тайлан	-Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, уулзалтын тэмдэглэл хөтлөх, гаргуулах материалын жагсаалтыг санамж бичгээр өгөх, -Хэрэгжүүлсэн арга хэмжээний анхан болон гүйцэтгэлийн шатны баримт материалыг авах, - -Бичгээр тайлбар авах, -Фото зургаар баталгаажуулах , -Бусад холбогдох баримт материал, ажлын зураг авалт,	-Гүйцэтгэлийн аудитын батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу цуглуулсан нотлох зүйлд шинжилгээ хийх, -Нэгтгэн дүгнэх, -Түүвэр судалгаа хийх, -Харьцуулалтын арга, -Тоон мэдээллийг боловсруулах, - Баталгаажуулалт хийх, -Нөхцөл байдлын шинжилгээ хийх, - Санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах,	-Үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээг боловсруулахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тооцоогүй
		1.1.2 Өмнөх онуудаас дамжин жил бүр үндсэн чиглэлд тусгагддаг арга хэмжээг дахин төлөвлөхдөө хэрэгжих үндэслэлийг тооцож байна уу?		-Удирдлагын тайлбар, -Гарсан эрх зүйн шийдвэр, -Баримтат болон дүн шинжилгээний нотлох зүйлс, -Өмнөх жилүүдийн тайлан, -Холбоотой талуудын тайлбар	-Хариуцан хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага, -Тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн, -Хэрэгжилтийн тайлан			-Жил бүр шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ хүрч хэрэгждэггүй арга хэмжээг давтан төлөвлөж, хэрэгжих үндэслэлийг тооцоогүй байх
		1.1.3 Үндсэн чиглэлийн арга хэмжээнд		-Удирдлагын тайлбар,	-Хариуцан хэрэгжүүлэх Засгийн газрын			-Үндсэн чиглэлийн арга хэмжээг

Аудитын асуулт	2 дах түвшний асуулт	3 дах түвшний асуулт	Шалгуур	Нотлох зүйлс	Нотлох зүйлсийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах аргууд	Мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргууд	Аудит болон дүн шинжилгээ хийхэд гарч болох хязгаарлалтууд
		шаардагдах хөрөнгийг төсвийн хүрээний мэдэгдэл, бусад эх үүсвэрт тулгуурлан бодитой тооцоолсон уу?	хөгжүүлэх үндсэн чиглэл", -"Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль", -Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөр, -Яамдын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, -Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, шалгуур үзүүлэлт,	-Гарсан эрх зүйн шийдвэр, -Баримтат болон дүн шинжилгээний нотлох зүйлс, -Төсвийн хуулиар тодорхойлсон зүйл, заалт, -Төсвийн хүрээний мэдэгдэл	гишүүн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, -Тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн, -Хэрэгжилтийн тайлан	-Судалгаа хийх, -Өмнөх жилүүдийн тайланг ашиглах, -Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, -Гүйцэтгэлийн аудитын журам		хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг бодитой тооцоогүй байх, -Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр байхгүй байх
		1.1.4 Үндсэн чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгө төсвийн болон бусад эх үүсвэрээр батлагдсан уу?		-Удирдлагын тайлбар, -Гарсан эрх зүйн шийдвэр, -Баримтат болон дүн шинжилгээний нотлох зүйлс, -Төсвийн хуулиар тодорхойлсон зүйл, заалт, -Судалгааны маягт -Хэрэгжилтийн тайлан	-Хариуцан хэрэгжүүлэх Засгийн газрын гишүүн болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, -Тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн			-Үндсэн чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгө төсвийн болон бусад эх үүсвэрээр батлагдаагүй байх
	2.1 Хэрэгжүүлэгч байгууллагууд үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?	2.1.1 Үндсэн чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулсан уу?	-УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоол, -УИХ-аас баталсан "Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого", -"Төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүд" -УИХ-аас баталсан "Монгол Улсын эдийн	-Ажлын төлөвлөгөө, нөхцөл байдлыг үнэлсэн шинжилгээний материалууд, үнэлэлт дүгнэлт, хэлэлцүүлгийн протоколууд, -Удирдлагын тайлбар -Хэрэгжилтийн тайлан, -Харьцуулсан судалгаа	-Хариуцан хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага, -Тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн, -Хэрэгжилтийн тайлан -Аудитын багийн гишүүдийн тайлан	-Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, уулзалтын тэмдэглэл хөтлөх, гаргуулах материалын жагсаалтыг санамж бичгээр	-Гүйцэтгэлийн батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу цуглуулсан нотлох зүйлд шинжилгээ хийх, -Нэгтгэн дүгнэх, -Түүвэр судалгаа хийх,	-Санхүүжилт саатсан, хөрөнгө оруулалт олгогдоогүй байх, хэрэгжилтийн явцад хяналт хангалтгүй байх, тулгарсан асуудлыг тухай бүрт нь шийдвэрлээгүй байх

Аудитын асуулт	2 дах түвшний асуулт	3 дах түвшний асуулт	Шалгуур	Нотлох зүйлс	Нотлох зүйлсийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах аргууд	Мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргууд	Аудит болон дүн шинжилгээ хийхэд гарч болох хязгаарлалтууд
		2.1.2 Батлагдсан хөрөнгийн эх үүсвэр нь арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүрэлцсэн үү?	засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам" -УИХ-аас баталсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", -"Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль", -Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөр, -Яамдын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, -Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, шалгуур үзүүлэлт, -Эрсдэлийн үнэлгээ, асуудлын шинжилгээ -Бусад арга, техник, технологи, стандарт, арга зүй,	-Ажлын төлөвлөгөө, нөхцөл байдлыг үнэлсэн шинжилгээний материалууд, үнэлэлт дүгнэлт, хэлэлцүүлгийн протоколууд, -Удирдлагын тайлбар -Хэрэгжилтийн тайлан, -Харьцуулсан судалгаа, -Судалгааны маягт	-Хариуцан хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага, -Тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн, -Хэрэгжилтийн тайлан -Аудитын багийн гишүүдийн тайлан	өгөх, -Хэрэгжүүлсэн арга хэмжээний анхан болон гүйцэтгэлийн шатны баримт материалыг авах, -Санал, асуулга авах, -Бичгээр тайлбар авах, -Фото зургаар баталгаажуулах, -Бусад холбогдох баримт материал, ажлын зураг авалт, - Судалгаа хийх, - Өмнөх жилүүдийн тайланг ашиглах, - Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, -Гүйцэтгэлийн аудитын журам	-Харьцуулалтын арга, -Тоон мэдээллийг боловсруулах, -Баталгаажуулалт хийх, -Нөхцөл байдлын шинжилгээ хийх, -Санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах	-Хэрэгжээгүй, хэрэгжилт дутуу арга хэмжээний шалтгаан, үр дагаварыг тооцож тодорхойлоогүй байх
		2.1.3 Зорилт арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө арвилан хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулсан уу?		-Ажлын төлөвлөгөө, үндсэн чиглэлийн арга хэмжээний асуудлыг нарийвчлан тодорхойлсон байдал, нөхцөл байдлыг үнэлсэн шинжилгээний материалууд, үнэлэлт дүгнэлт, хэлэлцүүлгийн протоколууд, -Судалгааны маягт	-Хариуцан хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага, тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн, -Хэрэгжилтийн тайлан -Аудитын багийн гишүүдийн тайлан			-Батлагдсан хөрөнгийн эх үүсвэр нь арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүрэлцээгүй, хөрөнгийг үр дүнтэй зарцуулаагүй байх
		2.1.4 Хэрэгжилт дутуу, хэрэгжээгүй арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, холбогдох албан		-Ажлын төлөвлөгөө, үндсэн чиглэлийн арга хэмжээний асуудлыг нарийвчлан тодорхойлсон байдал, нөхцөл байдлыг үнэлсэн шинжилгээний материалууд, үнэлэлт дүгнэлт,	-Хариуцан хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага, -Тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн,			-Хэрэгжилт дутуу, хэрэгжээгүй арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, холбогдох албан тушаалтанд

Аудитын асуулт	2 дах түвшний асуулт	3 дах түвшний асуулт	Шалгуур	Нотлох зүйлс	Нотлох зүйлсийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах аргууд	Мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргууд	Аудит болон дүн шинжилгээ хийхэд гарч болох хязгаарлалтууд
		тушаалтанд хариуцлага тооцсон уу?	-Онол, арга зүйн бусад шалгуур	хэлэлцүүлгийн протоколууд	-Хэрэгжилтийн тайлан -Аудитын багийн гишүүдийн тайлан			хариуцлага тооцоогүй байх
	3.1 Үндсэн чиглэлийн арга хэмжээний биелэлтийг бодитой үнэлж, тайлагнасан уу?	3.1.1 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийн үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн үү?	-УИХ-аас баталсан “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, -“Төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүд”, -УИХ-аас баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам”, -УИХ-аас баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, -“Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль”,	-Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, -Хэрэгжилтийн тайлан, -Удирдлагын тайлбар, -Харьцуулсан судалгаа, -Хэрэгжилтийг дэмжсэн бусад нотлох зүйлс, -Холбоотой талуудын тайлбар, -Судалгааны маягт	-Хариуцан хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага, -Тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн, -Хэрэгжилтийн тайлан -Аудитын багийн гишүүдийн тайлан	-Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, уулзалтын тэмдэглэл хөтлөх, гаргуулах материалын жагсаалтыг санамж бичгээр өгөх, -Хэрэгжүүлсэн арга хэмжээний анхан болон гүйцэтгэлийн шатны баримт материалыг авах, -Санал, асуулга авах, -Бичгээр тайлбар авах, -Фото зургаар баталгаажуулах, -Бусад холбогдох баримт материал,	-Гүйцэтгэлийн батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу цуглуулсан нотлох зүйлд шинжилгээ хийх, -Нэгтгэн дүгнэх, -Түүвэр судалгаа хийх, -Харьцуулалтын арга, -Тоон мэдээллийг боловсруулах, -Баталгаажуулалт хийх, -Нөхцөл байдлын шинжилгээ хийх, -Санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах	-Үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээний гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байх
		3.1.2 Үндсэн чиглэлийн биелэлтийг холбогдох журмын дагуу үнэн зөв тайлагнасан уу?		-Хэрэгжилтийн тайлан -Баримтат болон дүн шинжилгээний нотлох зүйлс, -Удирдлагын тайлбар, -Харьцуулсан судалгаа, -Хэрэгжилтийг дэмжсэн бусад нотлох зүйлс, -Холбоотой талуудын тайлбар -Судалгааны маягт	-Хариуцан хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага, -Тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн, -Хэрэгжилтийн тайлан -Аудитын багийн гишүүдийн тайлан			-Үндсэн чиглэлийн биелэлтийг холбогдох журмын дагуу үнэн зөв тайлагнаагүй байх

Аудитын асуулт	2 дах түвшний асуулт	3 дах түвшний асуулт	Шалгуур	Нотлох зүйлс	Нотлох зүйлсийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах аргууд	Мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргууд	Аудит болон дүн шинжилгээ хийхэд гарч болох хязгаарлалтууд
		3.1.3 Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт үр нөлөөтэй байна уу?	-Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, -Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөр, -Яамдын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, түүний биелэлт, -Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, шалгуур үзүүлэлт, -Бусад арга, техник, технологи, стандарт, арга зүй	-Хэрэгжилтийн тайлан, -Харьцуулсан судалгаа, -Баримтат нотлох зүйлс, -Дүн шинжилгээний нотлох зүйлс, -Хэрэгжилтийг дэмжсэн бусад нотлох зүйлс, -Холбоотой талуудын тайлбар -Судалгааны маягт	-Хариуцан хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага, -Тухайлсан албан тушаалтан буюу Хяналт-мониторинг, үнэлгээний мэргэжилтэн, -Хэрэгжилтийн тайлан -Аудитын багийн гишүүдийн тайлан	ажлын зураг авалт, -Судалгаа хийх, -Өмнөх жилүүдийн тайланг ашиглах, - Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, -Гүйцэтгэлийн аудитын журам		-Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт үр нөлөөгүй байх